



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 121

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Сайнцагаан сумын Ерөнхий боловсролын “Мандал” сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 196,246,569.84 (нэг зуун ерэн зургаан сая хоёр зуун дөчин зургаан мянга таван зуун жаран есөн төгрөг наян дөрвөн) мөнгөний балансын үнэ, 7,141,071.12 (долоон сая нэг зуун дөчин нэгэн мянга далан нэгэн төгрөг арван хоёр) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралт дахь хөрөнгийг “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХКомпанийн харьяа “Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар”-ын өмчид балансаас балансад шилжүүлсүгэй.


Хоёр: Аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга Г.Мягмарсүрэн болон “Мандал” сургуулийн захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100304

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2018 оны 12 сарын 13-ний өдрийн  
124 дугаар тогтоолын хавсралт

"Мандал" сургуулийн балансаас "Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ТӨХКомпанийн харьяа "Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбар"-ын өмчид шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

| Д/д         | Хөрөнгийн нэр<br>Дэд өргөөний<br>барилга | Ашиглалтад<br>орсон огноо | Тоо<br>хэмжээ | Нэгжийн үнэ    | Балансын үнэ   | Хуримтлагдсан<br>элэгдэл   | Үлдэгдэл өртөг   |
|-------------|--|---------------------------|---------------|----------------|----------------|--|--|
| 1           | Дэд өргөөний<br>барилга                  | 6/30/2018                 | 1             | 64,110,176.16  | 64,110,176.16  | 534,251.46   | 63,575,924.70  |
| 2           | 630 дэд өргөөний<br>цахилгаан            | 6/30/2018                 | 1             | 132,136,393.68 | 132,136,393.68 | 6,606,819.66   | 125,529,574.02   |
| <b>НИЙТ</b> |  |                           |               |                |                | <b>7,141,071.12</b><br>(долоон сая нэг<br>зуун дөчин нэгэн<br>мянга далан нэгэн<br>төгрөг арван хоёр<br>мөнгө) | <b>189,105,498.72</b><br>(нэг зуун наян есөн<br>сая нэг зуун таван<br>мянга дөрвөн зуун<br>ерэн найман төгрөг<br>далан хоёр мөнгө) |